МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 08 өдөр Дугаар А/179 Мандалговь

## Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 38 дугаар тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын дүгнэлт, Өлзийт, Өндөршил, Дэлгэрхангай сумдын ИТХ-ын санал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Дэлгэрхангай сумдын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдэд тогтоосон хэмжээ, солбицлын дагуу 3 жилийн хугацаагаар олгосугай.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу олгон, энэ тухай холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488190478

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 08-ны өдрийн А/181 тоот
захирамжийн хавсралт

НУТГИЙН МАЛ СҮРЭГТ ҮЗЛЭГ, АНГИЛАЛТАНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО

| № | Аймаг | Сум | Малын төрөл | Ангилалтанд хамрагдах мал | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийт | Хээлтүүлэгч | Хээлтэгч |
| 1 | Дундговь | Өндөршил | Адуу | 3000 | 100 | 2900 |
| 2 | | Сайнцагаан | Хонь | 20000 | 300 | 19700 |
| 3 | | Хулд | Тэмээ | 3000 | 30 | 2970 |
| 4 | | ЦСҮАА | Хонь | 187 | | 187 |
| 5 | | | Ямаа | 230 | | 230 |
| 6 | Нийт | | Бог | 20417 | 300 | 20117 |
| 7 | | | Бод | 6000 | 130 | 5870 |
| 8 | | | Нийт | 26417 | 430 | 25987 |